



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/47

Чингис хот

Худалдан авах ажиллагаа зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжих аймгийн Нэгдсэн эмнэлэгт яаралтай тусламжийн автомашин авах, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын тавилга, тоног төхөөрөмж авах ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
дарга:

Ц.Дэмбэрэлсайхан

Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн
дарга

Н.Үнэнбат

Орон нутгийн өмчийн газрын
Худалдан авах ажиллагааны ахлах
мэргэжилтэн

Гишүүд

Ц.Бат-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Ц.Дэмбэрэлсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010145